


БАТЛАВ: ЗАХИРАЛ



ДОК. ПРОФ Ч. БАТДЭЛГЭР, (Ph.D.),

2024 оны 04 -р сарын 22 ны өдрийн
захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлав.

**“ДАРХАН” ДЭЭД СУРГУУЛЬД 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ШИНЭЧИЛСЭН ЖУРАМ
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 23 дугаар зүйлийн 26.1.22 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалыг үндэслэн “Оюутан элсүүлэх журам”-ыг тус тус үндэслэн Дархан Дээд сургууль энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр суралцагчдад :/ Багш бага ангийн боловсрол /D011301/, Багш сургуулийн өмнөх боловсрол /D011201/ хөтөлбөрөөр суралцагчид хүсэлт гаргавал төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 1.3. Багш, суралцагчид төрөөс дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 102, 103 тоот тогтоол, ДаДэС-ийн захирлын 2024 оны 04 сарын 17-ны өдрийн 20 тоот тушаалаар батлагдсан “Багш мэргэжлээр суралцагчдад үзүүлэх дэмжлэгийн журам”-ыг тус тус баримтална.
- 1.4. “Дархан” Дээд Сургууль /ДаДэС/-д элсэн суралцахаар хүсэлт гаргагч, элсэлтийн комиссын ажлыг удирдан зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.5. БШУЯамнаас тогтоосон журам, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан /ДаДэС/-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэн суралцуулна.

ХОЁР.ЭЛСЭЛТИЙН КОМИССЫГ БАЙГУУЛАХ

- 2.1. Элсэлтийн комиссын бүрэлдэхүүн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг Дархан Дээд Сургуулийн захирлын тушаалаар батална.
- 2.2. “Дархан” Дээд Сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэн “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэж үзнэ.
- 2.3. Элсэлтийн комисс нь энэхүү журмыг баримтлан элсэхийг хүсэгчдийн материалыг шалгах, ур чадварын шалгалтыг зохион байгуулах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.

ГУРАВ. ДАРХАН ДЭЭД СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 3.1. ДаДэС-н бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгчид 2024 оны 5-р сарын 20-ны өдрөөс 2024 оны 7-р сарын 7-ны хооронд www.darkhandeed.mn хаягаар нэвтэрч бүртгэлийн цахим хуудсанд бүртгүүлэх буюу өөрийн биеэр холбогдох бичиг баримтаа авч ирж бүртгүүлнэ.
- 3.2. Аймаг орон нутгаас элсэхийг хүсэгчдийн бүртгэл болон хуваарь сонголтыг орон нутагт нэр заагдсан аймгуудад томилолтоор ажиллаж байгаа багш нар бүртгэнэ.
- 3.3. ДаДэС-н бакалаврын хөтөлбөрт аймгуудаас элсүүлэх оюутны хяналтын тоог тус сургуулийн удирдах зөвлөл тогтоох ба **МИДСК-ын** элсэлтийн салбар комиссоор дамжуулан хуваарь сонголт хийнэ.
- 3.4. **Доорхи шалгуурын аль нэгийг хангасан тохиолдолд элсэх эрхтэй болно.**
 - 3.4.1. Шалгуулагч бүр 3-аас доошгүй шалгалт өгнө .
 - 3.4.2. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/ Хөтөлбөр/-өөр 3-аас доошгүй жил ажилласан 30-аас дээш насны иргэн ЭЕШ өгөхгүйгээр элсэн суралцаж болно.
 - 3.4.3. Техникийн боловсролын дипломтой/ **С дипломтой**/ иргэн ХАА, Инженер технологи, хөгжмийн урлаг болон цэрэг цагдаагийн шаталсан сургалт бүхий сургуулийн төгсөгч, мэргэжлийн чиглэлийн дагуу дэвшин суралцах суралцагч
 - 3.4.4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн
 - 3.4.5. Гадаадын улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг Кембрижийн AS /advanced subsidiary/, A /advanced/, болон IB /international baccalaureate/ түвшний хөтөлбөр, IELTS /International English Language Testing System/, TOEFL /Test of English as a Foreign Language/, SAT /SchoIastic Aptitude Test/-ын үнэлгээг Монгол Улсын элсэлтийн шалгалтын үнэлгээтэй дүйцүүлж батламж олгоно. төвөөр дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн.
 - 3.4.6. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг бусадтай хамтран болон сургууль бие даан зохион байгуулна.
 - 3.4.7. Ур чадварын шалгалт авах комисс байгуулж шалгалтын материалыг бэлтгэж, сургуулийн хичээлийн байранд шалгалтаа авна.
 - 3.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй элсэгч нь аль нэг хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгч босго оноог хангасан, суралцах чин эрмэлзэлтэй, хүсэлт гаргасан элсэгчийг элсүүлэн суралцуулж болно
 - 3.4.9. Бакалаврын зэрэгтэй иргэнийг өдөр, орой, хөрвөх, хосолсон хэлбэрээр бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах ба бүртгүүлэгчдээс элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байхыг шаардахгүйгээр голч дүнг харгалзан элсүүлнэ.
 - 3.4.10. Дархан Дээд Сургуульд элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэдийн асуудлыг тусад нь журмаар зохицуулна.
- 3.5. Элсэгч нь тухайн сургуульд тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан хөтөлбөрийн дагуу элсэн суралцаж байгаад, өвчний улмаас, ар гэрийн гачигдал, гадаад явсан, цэргийн албанд татагдсан, хөтөлбөрөө шилжүүлсэн гэх мэт бусад хүндэтгэх шалтгаанаар удаа дараа жилийн чөлөө авч байсан бөгөөд, үргэлжлүүлэн суралцах хүсэлт гаргасан бол түүний хүсэлтийг харгалзан үзэж, өмнө нь судалсан кредитийг тооцон үргэлжлүүлэн суралцуулж болно.
- 3.6. Бүртгүүлэгч нь тус сургуульд элсэн орохоос өмнө энэхүү журамтай танилцсан байна.

3.7. ДаДэС-д сонгосон мэргэжлээрээ элсэхэд ямар хичээлээр ерөнхий шалгалт өгөхийг доорх хүснэгтээр харуулав.

Бакалаврын болон магистрын хөтөлбөрт оюутан элсүүлэх мэргэжлийн чиглэлүүд

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн нарийвчилсан чиглэл	Суралцах жил	Ерөнхий шалгалтын оноо тооцох хичээл			
					ЭЕШ-1	Босго оноо	ЭЕШ-2	Босго оноо
1	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол	Цэцэрлэгийн багш	2-4 жил	Монгол хэл Нийгэм	420	Ур чадвар/ Бичгийн ажил, тест ,ярилцлага, Кейс	420
2	011301	Багш, бага боловсрол	Бага ангийн багш	2-4 жил	Монгол хэл Математик	420	Ур чадвар/ Бичгийн ажил, тест ,ярилцлага, Кейс	420
3	011401	Багш, математикийн боловсрол	Математикийн багш Мэдээлэл зүйн багш	2-4 жил	Математик	420	Физик, Англи хэл	420
4	011424	Багш, хөгжмийн боловсрол	Хөгжмийн багш	2-4 жил	Монгол хэл, Нийгэм судлал	420	Ур чадвар / Бичгийн ажил, тест ,ярилцлага, Кейс /	420
5	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Англи хэлний багш	2-4 жил 2-4 жил	Англи хэл, Орос хэл	420	Монгол хэл , Нийгэм судлал	420
			Солонгос хэлний багш	2-4 жил				
			Япон хэлний багш	2-4 жил				
			Хятад хэлний багш	2-4 жил				
6	031301	Сэтгэл судлал	Сэтгэл судлаач	2-4 жил	Нийгэм судлал , Математик	420	Монгол хэл, Англи хэл,	420
7	041303	Менежмент	Менежер	2-4 жил	Математик	420	Англи хэл, Нийгэм судал	420
8	023101	Гадаад хэлний орчуулагч	Англи хэл	2-4 жил	Англи хэл, Орос хэл	420	Нийгэм судлал, Монгол хэл	420
			Япон хэл					
			Хятад хэл					
			Солонгос хэл					
9	041101	Нягтлан бодох бүртгэл	Нягтлан бодох бүртгэл	2-4 жил	Математик	420	Нийгэм судлал, Англи хэл	420
			Банк санхүү, Татварын даатгалын ня-бо	2-4 жил				
10	092301	Нийгмийн ажил	Сум, баг хорооны сургуулийн нийгмийн ажилтан	2-4 жил	Нийгэм судлал ,Англи хэл	420	Монгол хэл , Математик	420
11	101501	Аялал жуулчлал	Аялал жуулчлал, хөтөч /Англи, Япон	2-4 жил	Математик , Монгол хэл,	420	Нийгэм судлал, Англи хэл	420
12	Магистр Боловсрол судлал Бизнесийн удирдлага		1 жил	Бакалаврын түвшний дипломын голч дүн 2.8-с дээш				

3.8. Элсэлттэй холбоотой ерөнхий мэдээллийг “Дархан” Дээд Сургуулийн веб хуудас www.darkhandeed.mn болон Дархан Дээд Сургууль гэсэн / FACEBOOK / Аймгуудын зарын мэдээлэл хуудаснаа байрлуулна.

ДӨРӨВ: ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1. Бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсүүлнэ.
- 4.2. “Дархан” Дээд сургуулийн бакалаврын оюутан элсүүлэх хөтөлбөрт ерөнхий боловсролын сургууль төгссөн бүртгүүлэгч иргэн өрсөлдөх эрхтэй.
- 4.3. Бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөрт шаардлагатай хичээлээр ЭЕШ-т өгч боловсролын үнэлгээний төвөөс цахимаар олгосон батламжтай байна.
- 4.4. Бүртгүүлэгч нь ДаДэС-д бүртгүүлэхээс өмнө элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчийн буланд нэвтэрч өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, хэрэв асуудал байвал шийдвэрлүүлсэн байна.
- 4.5. Бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөрт шаардлагатай хичээлээр сүүлийн хоёр жилийн дотор / ЭЕШ / өгч батламж авсан байна.
- 4.6. Элсэгч / ЭЕШ / элсүүлэх мэргэжлийн чиглэлээр 420-с дээш оноо авсан тохиолдолд элсэн суралцах болзол хангасан гэж үзнэ.
- 4.7. Бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй иргэнийг дараах тохиолдолд элсэлтийн шалгалтын оноо шаардахгүйгээр элсүүлэн суралцуулж болно.

Үүнд:

- Дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэн
 - Дээд боловсролын хуулийн 18.2-д заасан сургуулийн төгсөгч
 - Элсэн суралцах мэргэжлийн чиглэл / Хөтөлбөр/-өөр 3-аас доошгүй жил ажилласан 30-аас дээш насны иргэн ЭЕШ өгөхгүйгээр элсэн суралцаж болно.
 - Олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 медальт байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт;
 - Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог, боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн.
- 4.8. Элсэгч нь сургуулийн элсэлтийн журамтай танилцаж, элсэлтийн системд бүртгүүлнэ.
 - 4.9. Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургууль төгсөгч олон улсын шалгалтын үнэлгээгээ элсэлтийн шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх эсвэл элсэлтийн шалгалтад хамрагдаж авсан онооныхоо аль өндөр оноогоороо сургуульд элсэн орж болно.

ТАВ: ДАРХАН ДЭЭД СУРГУУЛИЙН ЭРХ ҮҮРЭГ

5.1. Оюутан элсүүлэх журмыг Дархан Дээд Сургуулийн захиралын зөвлөлийн хурлаар батлана.

5.2. Ур чадварын шалгалт авах шалгалтын агуулга, хэлбэр, бүтэц, хугацаа, байршил, дүгнэх аргачлалыг боловсруулсан байна.

5.3. Ур чадварын шалгалтыг мэргэжлийн хөтөлбөрийн удирдамжыг баримтлан зохион байгуулна. / Хавсралт 1,2,3 /

- 5.4. Бакалавр болон мэргэжлийн шаталсан сургалтаар дэвшүүлэн суралцах суралцагч нь доорх материалыг бүрдүүлсэн байна.
 - 5.4.1. С диплом хуулбар
 - 5.4.2. Төгссөн сургуулийн захирлын тушаал / хуулбар үнэн гэсэн тамга тэмдэгтэй болон үндэсний архиваас баталгаажсан хуулбар /
 - 5.4.3. Иргэний үнэмлэх
 - 5.4.4. Ажилтай бол ажлын газрын тодорхойлт
 - 5.4.5. НДШ хуулбар
- 5.5. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/ Хөтөлбөр/-р 3-аас доошгүй жил ажилласан 30-аас дээш насны суралцагч нь доорхи материалыг бүрдүүлнэ
 - 5.5.1. Иргэний үнэмлэх
 - 5.5.2. Ажлын газрын тодорхойлт
 - 5.5.3. НДШ хуулбар
 - 5.5.4. Өргөдөл
- 5.6. Гадаад оюутан элсүүлэхдээ доорх материалыг бүрдүүлэх
 - 5.6.1. Тухайн иргэний үнэмлэх /орчуулгын товчоогоор баталгаажуулсан байх/
 - 5.6.2. Гадаад паспорт /орчуулгын товчоогоор баталгаажуулсан байх/
 - 5.6.3. Цээж зураг 3%
 - 5.6.4. Эрүүл мэндийн хуудас / ДОХ болон халдварт өвчин /
 - 5.6.5. Төгссөн сургуулийн гэрчилгээ / орчуулгын товчоогоор баталгаажуулсан байх/
- 5.7. Оюутан элсүүлэхтэй холбогдсон маргаан, гомдолыг дархан дээд сургуулийн элсэлтийн комиссын шийдвэрээр шийдвэрлэнэ.
- 5.8. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг сургууль бие даан зохион байгуулна.
- 5.9. Энэхүү журмын 3,4 -т заасан шаардлага, болзлыг хангасан бүртгүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч, элсүүлнэ.
- 5.10. Бүртгүүлэгчийн оноо тэнцсэн тохиолдолд бүрэн дунд боловсролын гэрчилгээ дэх дүн, авьяас чадвартайг илэрхийлэх нотлох баримтууд, эсээ, ярилцлага зэрэг нэмэлт шалгуур тавьж болно.
- 5.11. Ур чадварын шалгалт авах мэргэжил /хөтөлбөр/-ийн жагсаалтад багтсан сургалтын хөтөлбөрүүдээр ур чадварын шалгалтыг сургууль зохион байгуулна.
- 5.12. Тухайн тэнхимээс гаргасан ур чадварын шалгалтын комиссын шийдвэрээр зохицуулагдана.

ЗУРГАА: УР ЧАДВАРЫН ШАЛГУУР

- 6.1 Ур чадварын шалгалт авах мэргэжил /хөтөлбөр/-ийн жагсаалтад багтсан сургалтын хөтөлбөрүүдээр ур чадварын шалгалт авна.
 - 6.1.1 Багш хөгжмийн боловсролын хөтөлбөрөөр суралцагч
 - 6.1.2 Багш, бага боловсрол хөтөлбөрөөр суралцагч
 - 6.1.3 Багш, сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрөөр суралцагч
- 6.2 Ур чадварын шалгалтыг элсэн суралцах хөтөлбөрийн онцлогтой уялдуулан бичгийн ажил, тест, ярилцлага, кейс ажиллуулах, дуулах, бүжиглэх, хөгжимдөх, жүжиглэх, эсээ бичих, видео танилцуулга, сонсгол, хэмнэл шалгах, сэтгэц, зан үйлийн байдал, бие бялдрын бэлтгэгдсэн байдал, асуумж зэрэг хэлбэрээр авч, шалгуулагчийн ур чадварыг үнэлнэ.
- 6.3 Ур чадварын шалгалтын удирдамжийг ДаДэС-ийн сургуулийн элсэлтийн журамд оруулан баталгаажуулсан байна.
- 6.4. Ур чадварын шалгалтын удирдамжид дараах зүйлсийг заавал оруулсан байна.

Үүнд:

- Шалгуулагчийн бэлдэж ирэх зүйлс
- Гүйцэтгэх даалгаврын төрөл, хэлбэр
- Үнэлгээний шалгуур, Үзүүлэлт
- Шалгалтыг зохион байгуулалт, байршил, хугацаа.
- Сургууль шалгуулагч бүрийн ур чадварын анхны оноо буюу гүйцэтгэлийн хувийг хөтөлбөр бүрээр 100 онооноос тооцоолж гаргана.
- Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувь буюу анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-аас 800-ийн хооронд байна)-г хөтөлбөр бүрээр энэхүү журмын 3.2.9-д заасан аргачлалаар тооцно. Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

№	Анхны оноо (A)	Хэмжээс оноо (X)
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	560-639
6	80-84.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

6.5 Анхны оноог A, хэмжээст оноог X гэж тэмдэглээд дараах байдлаар хэмжээст оноо (X)-г тооцоолно. Үүнд:

6.5.1 Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол $X=200+A*4.66$

6.5.2 Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол $X=480+(A-60)*8$ гэсэн томъёогоор олно.

6.5.3 Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 480) болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

6.7. Шалгуулагчийн ур чадварын шалгалтын оноо нь хөтөлбөрийн хувьд хүчинтэй байна.

6.8. Зарим хөтөлбөрөөр элсэлт авах онооны босгыг элсэлтийн шалгалтын үндэсний хэмжээний босго онооноос дээш байхаар тогтоож болно.

6.9. Оюутан элсүүлэх мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн индекс, суралцах хугацаа, хэлбэр, нийт судлах багц цаг, хяналтын тоо, элсэлтийн шалгалтын хичээлийн босго оноо, сургуулийн шалгуур шаардлага, ур чадварын шалгалтын босго оноо зэрэг мэдээллийг сургуулийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

6.10. Сургууль нь сургалтын хэлбэр, хичээлийн жилийн бүтэцтэй уялдуулан аймаг, нийслэлээс оюутан элсүүлэх ажлыг цахимаар болон тухайн байршил дээр элсэлтийн шалгалт дууссан өдрөөс хойш зохион байгуулна.

- 6.11. Сургууль нь тухайн мэргэжил /хөтөлбөр/-ээр суралцахад тавигдах элсэлтийн шалгалтын онооны шаардлага хангасан, Удирдах зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг элсүүлнэ.
- 6.12. Өвлийн буюу 2 дахь удаагийн элсэлтийг энэхүү журмын 4.2-т баталсан элсэлтийн хяналтын тоог хөтөлбөр бүрээр гүйцээх байдлаар зохион байгуулна. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр өвлийн элсэлт зохион байгуулах бол хаврын элсэлтийн тоотой нэгтгэсэн байдлаар баталсан аргачлалын дагуу тооцож нэмэлт хяналтын тоог тогтооно.
- 6.13. Сургуульд гадаадын иргэдийг сургахад дараах шаардлагыг тавина.
- Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэдээс авсан монгол хэлний мэдлэг, чадварын шалгалт, эсвэл англи хэлний олон улсын шалгалтын оноог харгалзан элсүүлэн суралцуулна.
 - Тухайн улсын элсэлтийн шалгалттай дүйцэх шалгалтын оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан байна.
 - Гадаадын иргэн харьяатын газарт хандан тухайн гадаад оюутны Монгол Улсад оршин суух үнэмлэх авах хүсэлт гаргахдаа монгол хэлний шалгалтын дүнг хавсаргасан байна.
 - Гадаад хэлээр сургалт явуулдаг хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд тухайн гадаад хэлний шаардлага хангасан гадаадын иргэнийг элсүүлнэ.
- 6.14. Сургууль элсэлтийн комисс болон ур чадварын шалгалтын комиссыг захирлын тушаалаар байгуулна.
- 6.15. Элсэлтийн комисс нь оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа нэг маргаан, бүртгүүлэгч болон тэдний хууль ёсны төлөөлөгчийн гаргасан санал, гомдлыг холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлэх, элсэлтийн явцад хяналт тавих, элсэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулна.

ДОЛОО: ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛӨӨР ЭЛСҮҮЛЭХ

- 7.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын 3 хичээлийн дундаж нь 701-800 оноотой бол сургалтын төлбөрийн 100%, 601-700 оноотой бол сургалтын төлбөрийн 50%, 550-600 оноотой бол сургалтын төлбөрийн 20%-ийн, хөнгөлөлтийг эхний жил тус тус үзүүлнэ.
- 7.2. “Багш, математикийн боловсрол, Багш, англи хэлний боловсрол, Нягтлан бодох бүртгэл, Сэтгэл судлал, Нийгмийн ажилтан” хөтөлбөрөөр элссэн эрэгтэй элсэгч 2 хичээлийн дундаж 550-иас дээш оноо авсан бол сургалтын төлбөрийн 40% -ийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 7.3. Магадлан Итгэмжлэгдсэн хөтөлбөрт элссэн элсэгчийг төрөөс үзүүлж байгаа Багш хөгжлийн дэмжлэгт хамрагдана.
- 7.4. Эрэл ихтэй мэргэжлээр элссэн оюутан ОХЗ-д хамруулж болно.
- 7.5. Суралцагч өөрөө хөгжлийн бэрхшээлтэй 50 %, бүтэн өнчин 100%, гэр бүлийн гишүүний аль нэг нь хөгжлийн бэрхшээлтэй бол 70% -ийн хөнгөлөлтөд хамруулж суралцуулна.
- 7.6. Нэг гэр бүлээс 2 суралцагч оюутан суралцаж байгаа бол хамгийн бага төлбөртэй нэг суралцагчийн сургалтын төлбөрөөс 50–иар хөнгөлнө.
- 7.7. Суралцагч нь 500 км болон түүнээс хол байршилтай бол өвлийн амралтын 2 талын зардалыг олгоно.
- 7.8. Элсэгчид давхар хөнгөлөлт эдлүүлэхгүй.

НАЙМ. ХОСОЛСОН СУРГАЛТ

8. 9.1. Танхимын болон танхимын бус, эдгээрийн хосолсон сургалтын үйл ажиллагаа нь суралцагч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн интернэт сүлжээнд суурилуулсан сургалтын платформ ашиглан сургах, багш болон суралцагсдын идэвхтэй арга хэлбэрийг зохистойгоор хослуулан явуулна.
9. 9.2 Суралцагч нь үндсэн шаардлага болох интернэт сүлжээ бүхий суурин компьютер, зөөврийн компьютер болон таблет, эсвэл ухаалаг гар утастай байх ба интернэт орчинд дээрх төхөөрөмжүүдийг ашиглах чадвартай байна.
10. 9.2. Багшийн танхимын бус сургалтаар явуулсан / Classroom, Google meet, бусад платформуур/ хичээлийг суралцагч судлан хичээлийн даалгавар, бие даалт, сэдвийн шалгалтыг цаг тухайд нь өгнө.
11. 9.3. Төгсөлтийн шалгалтыг / Хавар, Намар / жилд 2 удаа өгөхдөө өөрийн биеэр заавал ирнэ.

ЕС. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 8.1. ДаДэС-д элсэхийг хүсэгчдийг холбогдох материалын хамт 2024 оны 8-р сарын 15-31 ны хооронд тус сургуулийн элсэлтийн комисс хүлээн авч бүртгэнэ. Мөн www.darkhandeed.mn хаягаар материалаа илгээж болно.
Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр элсэх болзол хангаж хяналтын тоонд багтсан элсэгчид сургуульдаа ирж бүртгүүлнэ.
- 8.2. Элсэгчид бүртгүүлэхдээ дор дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна.
 1. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ
 2. Сурагчийн хувийн хэрэг
 3. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж
 4. Сурагчийн хувийн хэрэг
 5. Иргэний үнэмлэх, 1% зурагЭдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
- 8.3. Элсэгчдийг бүртгэх үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.
- 8.4. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал ДаДэС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан элсэлтийн комисс шийдвэрлэнэ.